



# 2024 оны III улирлын тайлан

Хүчтэй. Хамтдаа.



## Агуулга

---

Гүйцэтгэх Захирлын илгээлт	3
Бидний тухай	4
Онцлох үйл явдал	6
Нийгмийн хариуцлага	7
Ард Апп	8
Компанийн засаглал	10
Хөрөнгө оруулалтын багц	11
Онцлох тоон үзүүлэлт	12

## Гүйцэтгэх Захирлын илгээлт

Эрхэм хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, харилцагчид та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Эдийн засгийн эрчимт өөрчлөлттэй нөхцөлд манай компаниудын өсөн нэмэгдэж буй гүйцэтгэлийг харуулсан III улирлын тайланг танилцуулж байгаадаа таатай байна. Монгол Улсын эдийн засаг хүлээлтээс давж, оны эхний хагаст 5.6 хувиар өссөн үзүүлэлттэй байсан бөгөөд үүнд уул уурхай, тээвэр, үйлчилгээний салбар голчлон нөлөөлсөн байна. Цаг уурын таагүй нөхцөл байдлаас үүдэн хөдөө аж ахуйн салбар ихээхэн хохирол амсаж, 9 сарын байдлаар 8.1 сая толгой мал хорогдсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2 дахин өссөн үзүүлэлт байсан хэдий ч бусад салбарын өсөлт энэхүү хохирлыг нөхөж чадлаа.

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк болон Азийн Хөгжлийн Банкнаас 2024 оны эдийн засгийн өсөлтийн таамгийг дэвшүүлэхдээ Монгол Улсын ДНБ-ий өсөлтийг 5.0 - 5.5 хувиар өснө хэмээн үзэж байна. Цаашид 2025 онд уул уурхайн салбар тэлж, хөдөө аж ахуйн салбар сэргэх хандлагатай байгаа тул эдийн засгийн өсөлт 8 хувьд хүрч, илүү их өсөлтийг үзүүлэх төлөвтэй гэжээ.

Ард Санхүүгийн Нэгдлийн компаниуд III улиралд дор бүрнээ амжилтаа ахиулсны зэрэгцээ Ард Аппын хөгжүүлэлтүүд эрчимтэй хийгдэж, банкны карт холболт, зорилтот хуримтлалын бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлснээс гадна бидний хүсэн хүлээсэн Ардын дебит карт харилцагчдын гарт хүрэхэд бэлэн боллоо. Хөгжүүлэлтийн хүрээнд харилцагчийн сегментчлэлийг нэвтрүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээний хэрэглээнд суурилсан хөнгөлөлт, урамшууллын таатай нөхцөлийг бий болгоод байна. Цаашид Аппын хэрэглээг дэмжих, өдөр тутмын худалдан авалтыг нэмэгдүүлэх зорилгоор Мерчантын экосистемийг тэлж, Pick n Pay хуваан төлөх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсээр байх юм.

Нэгдэл нь III улиралд Ард Апп хөгжүүлэлт хийгээд технологийн үйлчилгээг хариуцан ажилладаг ТэнГэр Системс ХХК болон харилцагчийн үйлчилгээний дуудлагын төв болох Ард Суппорт ХХК зэрэг зардлын төвүүдээ оновчтой болгоход анхаарч ажиллалаа. Энэ нь бүтцийн өөрчлөлт, шинэчлэлтийн хүрээнд хийгдсэн арга хэмжээ бөгөөд ашигт ажиллагааг дэмжихэд түлхэц үзүүлэх юм. Мөн бидний зүгээс Дэлхийн Шуудангийн Холбоо (Universal Postal Union) болон Монгол Шуудан ХК-тай хамтран хөдөө орон нутгийн 150 гаруй сумдад санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг ПОС төхөөрөмжийг нэвтрүүлэх томоохон төслийг шуудангийн дэд бүтэц болон дэвшилтэт технологийн тусламжтайгаар эхлүүлж, энэ оны III улиралд тестийн шатыг амжилттай хийсэн бол IV улиралд төслийн дараагийн үе шатыг эхлүүлэхээр төлөвлөөд байна. Нэгдлийн нийгмийн хариуцлагын хүрээнд дэлхийн энх тайвны бэлгэ тэмдэг Олимпын наадмыг зорин очиж, эх орныхоо алтан соёмбот төрийн далбааг хэдэнтээ мандуулсан Паралимпын баг тамирчдыг дэмжин ажилласандаа баяртай байгаагаа тэмдэглэе.

Бидний уламжлал болгон жил бүр зохион байгуулдаг Хөрөнгө Оруулагч Үндэстэн Чуулган 2024 оны 11 сарын 23-нд Блю Скай Тауэрт 8 дахь жилдээ зохион байгуулагдах гэж байна. Тус арга хэмжээг хамтран зохион байгуулж буй Анрид Медиа болон Ардын баг хамт олондоо амжилт хүсэхийн зэрэгцээ харилцагч, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч та бүхнийг хүрэлцэн ирэхийг хүндэтгэн урьж байна.

Хүндэтгэсэн,  
Батбилэгийн Золбоо



## Эрхэм зорилго

- Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоонот

## Алсын хараа

- Бүтээлч түйвээлтээр дэлхийд манлайлагч финтек нэгдэл

## Зорилт

- Бүтээлч түйвээлт
- Дижитал маркетинг
- Тогтвортой өсөлт

## Үнэт зүйлс

- Бид нэг зорилготой, түүндээ хүрэх зоригтой, зогсолтгүй багуудын хамтрал
- Бидний соёл "Мөс Хагалагч" буюу шинийг санаачлах, хэцүүг шийдэх эрмэлзэл
- Бидний зарчим хэлсэн бол хийнэ, эхэлсэн бол дуусгах хариуцлага
- Бидний давуу тал салбартаа ямагт тэргүүлэгч байх тасралтгүй суралцагч мэргэжлийн баг
- Бидний уриа "Хүчтэй. Хамтдаа" буюу ганцаараа хурдан явах бус хамтдаа холыг зорих

## Мөрдөх зарчим

- Ёс зүйн хэм хэмжээг өндөрт тогтоон дагаж, хууль тогтоомжийг чандлан мөрдөхийн зэрэгцээ хүйсийн тэнцвэртэй байдлыг хангаж ажиллана
- Харилцагчийн үйлчилгээг дээд зэрэгт барих бодлогыг чандлан мөрдөнө
- Нийгмийн хариуцлага өндөртэй, нийгэмд эерэг өөрчлөлтийг түүчээлж ажиллана
- Хууль, эрх зүйн болон бизнесийн орчиндоо шаардагдаж буй өөрчлөлтүүдийг бий болгохын төлөө санаачилга гаргаж ажиллана
- Байгаль орчин, эх дэлхийгээ хайрлан хамгаалах шилдэг стандартыг нэвтрүүлж ажиллана

## Давуу шинж чанар

- Өрсөлдөх чадвар, үр ашиг болон дэвшилтэт технологийг цогцлуулсан түншлэл
- Амжилттай хөрөнгө оруулалтын туршлага, ил тод засаглал
- Шинэ санаа, төслийг хэрэгжүүлэгч олон улсад танигдсан хамт олон
- Хөрөнгө оруулалтын тогтвортой өгөөж
- Зах зээлийн боломжийг хөрөнгийн үнэ цэн болгох туршлага
- Хөрөнгө оруулагч үндэстний танигдсан брэнд
- Үндэстний хэмжээний цогц дэд бүтэц
- Энтрепренер соёл

# Чонын бэлгэдэл

Бөртэ чоно, Гуа маралын удамт, хөх толбот Монголчуудын сүр хүч, хийморь сүлдний бэлгэ тэмдэг. Хамгийн гэр бүлсэг, өөрийн сүрэгт насан туршдаа үнэнч байж, тэднийгээ хамгаалж явдаг онцлогтой эл амьтнаар Монгол эр хүний эрэмгий чанарыг дүйцүүлэн дүрсэлжээ.



## Эх чоно

Сүргийн тэргүүний нөмөр түшгийг бараадан амьдардаг эмэгчний ёсыг сэрвээнд нь наалдан яваагаар илэрхийлжээ.



## Үр төл

Амьтан бүхэн үр төлийнхөө төлөө зүрх сэтгэлээ өгч, тэмцэж амьдардгийг эцэг эхийнхээ зүрхэн тушаа хярсан бяцхан бэлтрэгийн дүрээр харуулжээ.



## Эцэг чоно

Сүргийн манлай эцэг чоно эмэгчнээ нуруундаа үүрч, үр төлөө зүрхэндээ тээж яваагаар дүрсэлжээ.



## Онцлох үйл явдал



Сингапур Улсад төвтэй хиймэл оюун ухаанд суурилсан баялгийн удирдлагын платформ Investbanq-тай хамтын ажиллагааны санамж бичиг үзэглэв.



Ард Кредит 13.5 тэрбум төгрөгийн НЭЭЛТТЭЙ БОНД гаргав.



Ардын Тэтгэврийн Сан ХХК ISO27001:2022 мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандартыг амжилттай нэвтрүүлэв.



Ард дебит картыг харилцагчдадаа хүргэхэд бэлэн болов.



Mining Week 2024 - Монголын уул уурхайн хамгийн том форумд Ард Даатгал, Ард Секюритиз, Ардын Тэтгэврийн Сан компаниуд оролцов.



Монголын анхны CoinBack урамшууллын системийг Ард App хэрэглэгчид болон хамтрагч байгууллагууддаа нээв.



Өөдлөн дэвжихийн бэлгэдэл нөхөрсөг санхүүч бэлтрэг Өнди дүр мэндлэв.



Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан Ард App хэрэглэгчдэдээ хамгийн онцгой урамшууллын богцыг задлав.

## Нийгмийн хариуцлага



Mongolia Economic Forum | YOUTH 2024-г Ардын хамт олон дэмжин ажиллав.



35 жилийн түүхт Харанга хамтлагийн ойн баярын тоглолтод ивээн тэтгэгчээр оролцов.



Тэнүүн Кап 2024 - Талбайн теннисний тэмцээнийг дэмжин ажиллав.



Парис 2024 Паралимпын наадамд эх орноо төлөөлөн оролцож буй баг бүрэлдэхүүнийг дэмжин ажиллав.



Ардын Мэдээ: Баяр наадмын тусгай дугаараа хүргэв.



30 жилийн түүхт Монголын ууган даатгалын байгууллага Ард Даатгал салбартаа анхлан тогтвортой хөгжлийн тайланг бэлтгэн танилцуулав.




6 сарын 3-8-ны өдрүүдэд Хөвсгөл, Булган, Эрдэнэт, Дархан, Сэлэнгэ аймгуудыг зорин очиж, харилцагчдадаа үйлчилгээ үзүүлэв.




Шинийг эрэлхийлэгч залуусын цугларалт UPDATE 2024 арга хэмжээнд оролцож, Ард Апп, АрдКидс үйлчилгээг танилцуулав.

## Ард Апп




Ард Аппад бүх төрлийн банкны картаа холбох боломжтой болов.



Хуримтлал дуусах өдрөө хүссэнээрээ сонгож, хүссэн хугацаагаараа хуримтлал үүсгэх боломжтой Зорилтот хуримтлалыг Ард Аппаар нээх боломжийг нээв.



Ардкойнд тулгуурласан хамгийн бага хүүтэй, ардкойны хэмжээ өсөх тусам зээлийн дүн нэмэгдэж, зээлийн хүү буурах Альфа, Альфа+ онлайн зээлийн үйлчилгээг нэвтрүүлэв.





## Ард Апп

	2023.III	2023.IV	2024.III	Өмнөх оны мөн үетэй харьцуулахад
Нийт хэрэглэгч	1,055,099	1,063,799	1,095,422	3.8%
Шинэ хэрэглэгч	12,898	27,077	31,623	145.2%
АрдКидс хэрэглэгч	47,924	49,666	53,887	12.4%
Нийт гүйлгээний тоо	1,905,236	2,832,755	2,655,203	39.4%
Татан төвлөрүүлсэн хадгаламжийн НИЙТ ДҮН (тэрбум төгрөгөөр)	17.3	24.77	27.09	56.6%
Цахим зээл олголт (тэрбум төгрөгөөр)	54.16	74.04	79.83	47.4%
Хувьцааны арилжаа (тэрбум төгрөгөөр)	7.8	10.4	12.6	61.5%
Нийт шилжүүлэг (тэрбум төгрөгөөр)	288.45	401.07	392.15	36.0%

## Компанийн засаглал

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт Хувьцаат компани нь ес буюу түүнээс дээш Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байхаар заасны дагуу Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь ТУЗ-ийн есөн гишүүнтэй ажиллаж байна. Үүнээс таван гишүүн нь хараат бус гишүүн бөгөөд ТУЗ-ийн бүх гишүүд банк, санхүүгийн салбарт 15-аас дээш жил ажилласан туршлагатай мэргэжилтнүүд юм. Одоогоор ТУЗ-ийн дэргэдэх гурван хороо үйл ажиллагаа явуулж, өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлж байна.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ нь 2024 оны III улирлын байдлаар нэг удаагийн ээлжит хурал, гурван удаагийн эчнээ санал хураалт явуулж, Нэгдлийн стратеги бүтцийн өөрчлөлт, охин компаниудын ТУЗ-ийн шинэ бүрэлдэхүүнд холбогдох нийт таван тогтоолыг батлав. Компанийн зүгээс ТУЗ-өөс гаргасан тогтоол шийдвэрүүдийг холбогдох журамд заасны дагуу нээлттэй мэдээлэн ажилладаг болно.

## Компанийн засаглалын кодекс

Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь энэ оны III улиралд Санхүүгийн Зохицуулах Хорооноос ирүүлсэн Засаглалын кодексын хэрэгжилтийн өөрийн үнэлгээний хянан баталгаажилтийг хүлээн авч, цаашид компанийн зарим дүрэм журам, бодлогын баримт бичгийг шинэчлэн батлах, хянан нийцүүлэлт хийх, улмаар Засаглалын кодексын хэрэгжилтийн үнэлгээг ахиулах тал дээр зорилт тавин ажиллаж байна.



**Ч.ГАНХУЯГ**

ТУЗ-ийн Дарга  
Ард Санхүүгийн Нэгдэл



**БРУНО Рашле**

Дэд дарга  
Шродер Адвек



**АРНО Вентура**

Удирдах Партнер  
Гожо Компани



**А.СҮХДОРЖ**

БСБ Сервис  
ГрайлСити Монгол  
МОСТ Финтек компаниудын  
үүсгэн байгуулагч



**М.СЭРГЭЛЭН**

Захирал, Монгол Коосэн  
Технологийн Коллеж



**О.ОДБАЯР**

ТУЗ-ийн Дарга  
Ард Даатгал ХК



**Ч.МӨНХБАТ**

Ерөнхийлөгч  
Саусгоби сэндс



**МИХАИЛ Зелдович**

Хяналтын зөвлөлийн дарга  
Кокуун капитал



**Роланд Нэш**

Үүсгэн байгуулагч түнш  
VPE Капитал

— Ердийн гишүүн

— Хараат бус гишүүн

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

АУДИТЫН  
ХОРОО

ЗАСАГЛАЛ, НЭР  
ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН  
УРАМШУУЛЛЫН ХОРОО

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ  
ЭРСДЭЛИЙН ХОРОО

## Хөрөнгө оруулалтын багц - Ард Санхүүгийн Нэгдэл



## ХӨВСГӨЛ

### ХӨВСГӨЛ ХК



- МХБ дээр нээлттэй компани
- Ард Санхүүгийн Нэгдлийн эзэмшил
- Холбоотой этгээдийн эзэмшил

## ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### Банкны кластер

Ард Кредит ₮13.5 тэрбумын нээлттэй бондын эрх авсан ба одоогоор ₮10 тэрбумыг амжилттай татан төвлөрүүлээд байна.

Ард Актив компанийн нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 35.1%-аар өсөж ₮53.5 тэрбумыг давлаа.

Ард Лизинг оны эцэс гэхэд нийт борлуулалтыг ₮7 тэрбумд хүргэхээр ажиллаж байна.

### Даатгалын кластер

Ард Даатгалын хураамжийн орлого өмнөх оны мөн үеэс 45.2%-аар өсөж ₮33.1 тэрбумд хүрсэн байна.

Ардын Тэтгэврийн Данс компанийн удирдаж буй хөрөнгө оруулалтын багц өмнөх оны мөн үеэс 29%-аар өсөж ₮40 тэрбумд хүрлээ.

### Хөрөнгө оруулалтын банкны кластер

Ард Секюритиз ҮЦК-ийн нийт орлого өмнөх оны мөн үеэс 39.5%-аар өсөж ₮2.5 тэрбумд хүрчээ.

Ард Пропертиз компанийн нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 41.0%-аар өсөж ₮26.8 тэрбумд хүрсэн.

Нийт хөрөнгө  
**₮193 тэрбум**  
▲ 38.5%

Зээлийн багц  
**₮105 тэрбум**  
▲ 26.4%

Санхүүжилт  
**₮151 тэрбум**  
▲ 31.4%

Нийт хөрөнгө  
**₮97 тэрбум**  
▲ 22.9%

Хөрөнгө  
оруулалтын багц  
**₮72 тэрбум**  
▲ 20.0%

Эздийн өмч  
**₮18 тэрбум**  
▲ 36.6%


Нийт хөрөнгө  
**₮39 тэрбум**  
▲ 38.5%

Хөрөнгө  
оруулалтын багц  
**₮8 тэрбум**  
▲ 5.0%


Санхүүжилт  
таталт  
**₮49 тэрбум**  
▲ 39.5%

## ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


**Нийт орлого**  
(сая төгрөг)



**Хөрөнгө оруулалтын орлого** (сая төгрөг)



**Хуримтлагдсан ашиг**  
(сая төгрөг)



**Урт хугацаат хөрөнгө оруулалт** (сая төгрөг)



Орлогын тайлан (сая төгрөг)	2023.III	2024.III
<b>Нийт орлого</b>	<b>5,049</b>	<b>8,448</b>
Удирдлагын болон үйл ажиллагааны зардал	5,310	4,225
Санхүүгийн зардал	2,302	2,745
Бусад зардал	2,038	284
<b>Нийт зардал</b>	<b>9,650</b>	<b>7,254</b>
Татварын өмнөх ашиг	-4,612	1,291
Татварын зардал	38	-30
<b>Цэвэр ашиг</b>	<b>-4,650</b>	<b>1,321</b>

Санхүүгийн байдлын тайлан (сая төгрөг)	2023.III	2024.III
Авлага	35,755	48,123
Урт хугацаат хөрөнгө оруулалт	79,412	75,704
Бусад хөрөнгө	20,401	8,223
<b>Нийт хөрөнгө</b>	<b>135,745</b>	<b>134,335</b>
Өглөг	19,864	27,384
Богино хугацаат зээл	3,709	2,154
Урьдчилж олсон орлого	11,587	9,783
Урт хугацаат зээл	17,299	12,493
<b>Нийт өр төлбөр</b>	<b>57,585</b>	<b>59,034</b>
Хувьцаат капитал	28,614	28,614
Хуримтлагдсан ашиг	14,635	26,021
<b>Эздийн өмч</b>	<b>78,160</b>	<b>75,301</b>



# ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН 2024